ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН НИЙГМИЙН БОДЛОГЫН МЭРГЭЖИЛТНИЙ 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг: Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт.**

| № | Зорилтын хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн тайлан | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин /биелэлт/ | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| Зорилт 1. "**Нийгмийн салбарын талаарх хууль тогтоомж, бодлого, шийдвэр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, арга зүйгээр хангах, тайлагнах"** зорилтын хүрээнд: | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1. Салбарын холбогдох хууль тогтоомж, Засгийн газар, аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргаас гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг орон нутагтаа хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, тайлагнах, холбогдох байгууллагад хүргүүлэх | Хууль тогтоомж, дээд газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилт хангагдсан байна. Хагас, бүтэн жилээр үнэн бодитой тайлагнасан байна. Хэрэгжилтийг урд оны суурь түвшинд хүргэнэ. | Хэрэгжилт-90% | 100% | Засгийн газрын тогтоол шийдвэрийн биелэлтийг 4 зорилтын хүрээнд 6 заалт, аймгийн засаг даргын 3 захирамж, аймгийн ИТХ-ын 3 тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. | 2024.01.01 2024.12.30 | 100 |
| 2. | Дэд арга хэмжээ -1.1.1. Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг орон нутагтаа зохион байгуулах, тайлагнах | | Хэрэгжилт-90% | 15% | Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг орон нутагтаа зохион байгуулж 4 заалтын биелэлтийг хагас, бүтэн жилээр тайлагнасан. | 2024.01.01 2024.12.30 | 100 |
| 3. | Дэд арга хэмжээ -1.1.2. Аймгийн Засаг даргын захирамжын хэрэгжилтийг ханган ажиллах, тайлагнах | | Хэрэгжилт-100% | 10% | Аймгийн Засаг даргын Ажлын хэсэг байгуулах тухай 2015.02.17 Дугаар А/55, Хамтарсан багийн үйл ажиллагаа эрчимжүүлэх тухай 2017.11.15 Дугаар а/531, 2017.11.16 Аймгийн залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг | 2024.01.01 2024.12.30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шинэчлэн батлах тухай<br>2021.06.28 Дугаар А/317 тоот захирамжийн хэрэгжилтыг ханган ажилласан. | | |
| .4. | Дэд арга хэмжээ -1.1.3. Аймгийн ИТХ-ын тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллах, тайлагнах | | Хэрэгжилт-100% | 40% | Аймгийн ИТХ-аас батлан гаргасан Хүүхэд хамгааллын бодлого батлах 2015.07.03 Дугаар 53, Хөтөлбөр батлах тухай (Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх 2021-2024) 2021.06.07Дугаар 37, Шатар хөтөлбөр батлах тухай 2021.04.30 Дугаар 35 тогтоолын хэрэгжилтийг ханган ажилласан. | 2024.01.01<br>2024.12.30 | 100 |
| 5. | Дэд арга хэмжээ-1.1.4. Сумын ИТХ-ын тогтоолын хэрэгжилтыг ханган ажиллах, тайлагнах | | Хэрэгжилт-90% | 35% | Сумын ИТХ-аас батлан гаргасан 2 гаргасан Хүүхэд хамгааллын бодлого, Биеийн тамир спортыг хөгжүүлэх бодлогын хэрэгжилтийг ханган ажилласан бөгөөд Биеийн тамир спортын бодлогын хэрэгжилтийг сумын ИТХ-аар хэлэлцүүлж 85,5% буюу хангалттай хэрэгжиж байна гэсэн үнэлгээ өгсөн. | 2024.01.01<br>2024.12.30 | 100 |
| 6. | Арга хэмжээ:1.2. Салбарын үндэсний болон дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллах, тайлан мэдээг хугацаанд нь үнэн зөв тайлагнах, холбогдох байгууллагад хүргүүлэх | Төлөвлөгөө боловсруулж хэрэгжилтийг ханган ажилласан байна. | Хэрэгжилт-90% | 100% | Залуучуудын эх оронч үзэл төлөвшүүлэх" үндэсний хөтөлбөр, "Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх" аймгийн хөтөлбөр, "Хүүхэд хамгааллын бодлого" хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулж биелэлтийг ханган ажилласан. | 2024.01.01<br>2024.12.30 | 100 |
| 7. | Дэд арга хэмжээ:1.2.1 "Залуучуудын эх оронч үзэл төлөвшүүлэх" үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллах, тайлагнах | 1.2.1.Хөтөлбөрийн хэрэгжилтийг урд оны суурь түвшинд хүргэнэ. | Хэрэгжилт-90% | 50% | "Залуучуудын эх оронч үзэл төлөвшүүлэх" үндэсний хөтөлбөр 4 зорилтын хүрээнд 4 ажил хийгдэхээр төлөвлөгдөж биелэлт 92,5%-тай хэрэгжсэн. | 2024.01.01<br>2024.12.30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 8. | Дэд арга хэмжээ:1.2.2 "Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх" аймгийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах, тайлагнах | 1.2.2.Хөтөлбөрийн хэрэгжилтийг урд оны суурь түвшинд хүргэнэ. | Хэрэгжилтийн хувь-90 | 50% | Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх аймгийн хөтөлбөр 3 зорилтын хүрээнд 19 ажил хийхээр төлөвлөгдөж биелэлт 73,8% тай байна. | 2024.01.01 2024.12.30 | 70 |
| 9. | Арга хэмжээ 1.3. Аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, улс, аймгийн эдийн засаг нийгмийн хөгжүүлэх бодлогын баримт бичиг болон бусад холбогдох хууль тогтоомжийн чиг үүрэгт хамаарах зорилтуудыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, тайлагнах | Зорилтуудыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан байна. Урд оны суурь түвшингээс бууруулахгүй байна. | Хөтөлбөрийн хэрэгжилт -90% | 100% | Аймгийн ЗДҮАХ 5 зорилтын хүрээнд 20 хийгдэж гүйцэтгэл 87,2,0%, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр 4 зорилтын 9 ажил хийхээр тусгагдаж биелэлт 90,6%-тай байна. | 2024.01.01 2024.12.30 | 100 |
| 10. | Дэд арга хэмжээ 1.3.1 Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн өөрт хамааралтай зорилтуудыг хэрэгжүүлэх | Хэрэгжилтийг 90%-д хүргэнэ. | Хөтөлбөрийн хэрэгжилт-80% | 40% | Аймгийн ЗДҮАХ-ийн өөрт хамааралтай 5 зорилтын хүрээнд 20 заалтын биелэлтийг тооцоход өөрөөс шалтгаалаагүй 2 ажил тасарсан, бусад ажлын гүйцэтгэл 87,2%-тай байна. | 2024.01.01 2024.12.30 | 90 |
| 11. | Дэд арга хэмжээ 1.3.2. Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн өөрт хамааралтай заалтуудыг хэрэгжүүлэх, тайлагнах | Урд оны суурь түвшингээс бууруулахгүй байна | Хөтөлбөрийн хэрэгжилт -90% | 40% | Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн өөрт хамааралтай 4 зорилтын хүрээнд 9 заалтын биелэлтийг тооцож холбогдох маягтын дагуу гаргаж үнэлэхэд 100 хувийн хэрэгжилттэй 7 ажил, 90 хувийн хэрэгжилттэй 2 ажил байв. | 2024.01.01 2024.12.30 | 100 |
| 12. | Дэд арга хэмжээ 1.3.3. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн өөрт хамааралтай заалтуудыг хэрэгжүүлэх, тайлагна | Хэрэгжилтийг 100%-д хүргэнэ. | Хэрэгжилт-100% | 10% | Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн өөрт хамааралтай 3 заалтын биелэлтийг гаргаж холбогдох мэргэжилтэнд хүргүүлсэн. | 2024.01.01 2024.12.30 | 100 |
| 13. | Дэд арга хэмжээ: 1.3.4.Аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн өөрт хамааралтай заалтуудыг хэрэгжүүлэх, тайлагнах | Урд оны суурь түвшингээс бууруулахгүй байна | Хэрэгжилт-70% | 10% | Аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн өөрт хамааралтай 3 заалтын биелэлтийг тооцон гаргаж холбогдох мэргэжилтэнд хүргүүлсэн. | 2024.01.01 2024.12.30 | 100 |
| 14. | Арга хэмжээ 1.4. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги | Төлөвлөгөө боловсруулж хэрэгжилтийг | Хэрэгжилт- | Зохион байгуулах арга хэмжээ - | "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө" бодлогын бичиг баримт нь 8 зорилтын | 2024.01.01 2024.12.30 | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах (2022-2031он) | хանган ажилласан байна. Жендерийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх 2-оос доошгүй арга хэмжээ зохион байгуулсан байна. | 70.0% | 2 | хүрээнд 17 ажил хийхээр төлөвлөгдөж, 2 ажил хийгдээгүй байна. | | |
| **Зорилт 2. Гэр бүлд ээлтэй хөгжил, хамгааллын бодлогыг хэрэгжүүлэн гэр бүлийн хөгжлийг дэмжиж, тогтвортой, чадавхижсан гэр бүлийг төлөвшүүлнэ**" зорилтын хүрээнд | | | | | | | |
| 1 | Арга хэмжээ 2.1. Залуу гэр бүлд чиглэсэн зөвлөгөө өгөх үйлчилгээг нэвтрүүлж, гэрлэлтийн үнэ цэнэ, гэр бүлийн үүрэг хариуцлагын талаарх ойлголтын нэмэгдүүлэх | Залуучуудын гэр бүлийн боловсролыг дээшлүүлэх талаар 2-оос доошгүй нөлөөллийн ажлыг зохион байгуулна. | - | Арга хэмжээний тоо-2 | Аймагт зохион байгуулагдсан "Аз жаргалтай гэр бүл-2" вакум сургалтанд 1 гэр бүлийг оролцуулж, ЗДТГ-аас замын зардал 50.000 төгрөгийн дэмжлэг үзүүлж ажилласан. ЕБС-ийн сурагчдад хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх сургалтыг хийж нийт 53 сурагч хамрагдсан. Иргэдийн эрүүл мэндийн боловсролд зориулсан мэдээллийн тоо-56 нийт хандалт-502 байна. Давхардсан тоогоор нийт 1846 эрчүүд болон өсвөр үе, залуучуудыг үзлэг шинжилгээнд хамрагдсан. Үүнээс 118 нь цэргийн насны залуучууд жин, өндөр, дотор, арьс, мэдрэл, чих хамар хоолой, нүд, гэмтэл, мэс засал, ХДХВ, тэмбүү, Элэгний В, С вирус илрүүлэх, ШЕШ, Биохими шинжилгээнд хамруулан урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулсан 33 эрүүл мэндээр тэнцэж 72 залуу буюу 61% нь эрүүл мэндийн шалтгаанаар тэнцээгүй байна. Тэнцээгүй залуучуудын дийлэнх хувийг | 2024.05.15. 2024.12.10 | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | илүүдэл жин, шүдний өвчлөл, зүрх судасний өвчлөл зээлж байна. Мөн жирэмсэн эмэгтэй 30, бусад 270 иргэн нь амбултори, урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан иргэд байна. ЭМТ-өөс тэдэнд эрүүл мэндийн боловсрол олгох талаар зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан байна.<br>Арга хэмжээ-2, хамрагдсан залуучуудын тоо-171 | | |
| 2 | Арга хэмжээ 2.2. Гэр бүлд ээлтэй орчин бүрдүүлэх, эцэг эхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, хүүхэд хүмүүжүүлэх зөрэг аргыг түгээн дэлгэрүүлэх сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах | Хүүхэд хүмүүжлийн зөрэг арга сургалтыг иргэдийн дунд зохион байгуулж иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.<br>Хамрагсдын тоог суурь түвшинд хүргэнэ. | Зохион байгуулсан арга хэмжээний тоо: 8<br>Хамрагдсан хүний тоо -423 | Сургагч багш нартай хамтран сургалтыг зохион байгуулж 420 хүнийг хамруулсан байна. | "Хүүхэд хүмүүжүүлэх зөрэг арга барилаас суралцъя" арга хэмжээнд Ерөнхий боловсролын сургуулийн 3-5 дугаар ангийн сурагчдын төлөөлөл, эцэг, эх, асран хамгаалагчийн хамт оролцож нэг өдрийг үр бүтээлтэй өнгөрүүлсэн. Тус арга хэмжээн нь "Үнэг, чоно хоёр" үлгэрийг хүүхдүүдэд уншиж өгч, утгыг нь яриулж, сэдвийн хүрээнд зураг зуруулах, мөн эцэг, эх асран хамгаалагчид хүүхэд хүмүүжлийн зөрэг арга, хүүхдээ хэрхэн өсгөн хүмүүжүүлж буй туршлагаасаа хуваалцаж, "Дэлгэр зун цаасан наамал", ТАТАТУНГАА танин мэдэхүйн тэмцээнд хүүхэдтэйгээ хамтран оролцлоо. Тус арга хэмжээнд нийт 18 сурагч, 18 эцэг эх, асран хамгаалагч оролцож 60,000 төгрөг зарцуулсан.<br>Сумын номын санч, НТБ-ын нэгжийн багштай хамтран Ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн сурагчид, дотуур байрны сурагчдын дунд "Угийн бичиг" хөтлөх арга зүйн сургалтыг 2 удаа зохион байгуулж 53 хүүхэд хамрагдсан. Сурагчдын дунд дадлага ажил хийлгэж, "Алтан хонх" танин мэдэхүйн тэмцээнийг зохион байгуулж угийн зураглал, | 2024.03.01<br>2024.12.30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бичиглэл бичих арга барилд сургасан. "Нэг өрх-Нэг угийн бичиг" аяны хүрээнд 2 бичлэг бэлтгэн байршуулж, угийн бичиг хөтөлдөг өрхийн үзэсгэлэн гаргаж, гарын авлага материал тараан, шилдэг бүтээлийг аймагт зохион байгуулсан үзэсгэлэнд оролцуулснаар шилдэг угийн бичигтэн өрх төрөлд Д.Данаасүрэн дэд байр, шилдэг сум төрөлд тусгай байр эзэлсэн амжилт үзүүлсэн. Үндэсний тоглоом наадгайн ач холбогдолын танин мэдүүлэх, хэрхэн яаж тоглохыг зааж сургах, цахим орчны хэрэглээг багасгах зорилгоор "Бүх нийтээрээ бөгж нийлүүлье" 1 сарын аяныг 1-12 дугаар ангийн сурагчдын дунд зохион байгуулж 317 сурагч бөгж нийлүүлж сурсан үр дүн гарсан. Мөн аймгийн Насан туршийн боловсролын нэгжтэй хамтран зохион байгуулсан "Байгууллагын соёл, харилцаа хандлага", "Зорилгоо тогтвортой тууштай барих нь" сургалтад төрийн албан хаагч 47, "Аз жаргалтай амьдрахуй" сургалтад 29 ахмад оролцсон. Гэр бүлд ээлтэй орчин бүрдүүлэх, эцэг эхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлээр "Цахим орчинд зөв суралцъя", Цахим орчинд хүүхэд гэр бүлийн зүй зохистой харилцаа" зэрэг сэдвээр контент зарлаж тус бүр 6 бичлэг ирүүлсэн бөгөөд эхний 3 байр эзлүүлж Дурсамж мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан. Нийт 480.0 төгрөг зарцуулсан. Шалгарсан бичлэгийг "Хамтарсан баг" цахим сүлжээнд байршуулсан. Хандалтын тоо-380. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Сургалт, арга хэмжээ-8, хамрагдсан хүний тоо-482, хамтран ажилласан байгууллагын тоо-3, зарцуулсан хөрөнгө -819,8 төг | | |
| 3 | Арга хэмжээ 2.3. "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль", "Хүүхдийн эрхийн тухай хууль", Хүүхэд хамгааллын тухай хууль" тогтоомжийг иргэдэд сурталчлан таниулах | Гэр бүлийн хүчирхийллийг илрүүлж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан байна. Хүчирхийлэлд өртөх магадлал бүхий өрхийн судалгааг гаргасан байна. Оролцогчдын тоог урд оноос бууруулахгүй байна. | Зохион байгуулсан сургалт -3 Хамрагдсан хүний тоо- 200 | Хууль тогтоомжийг иргэдэд сурталчлан таниулж 400 иргэнийг хамруулсан байна. | Аймгийн ГХУСАЗСЗ –тэй хамтран сумын иргэд, албан байгууллагуудын ажилтан, албан хаагчдад "Одоо л больё" аяны хүрээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулж 110 орчим иргэд, албан хаагчдыг хамруулсан. Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Хүүхдийн эрхийн тухай хуулиар 230ш гарын авлага тараан олгож цахим орчинд постер бэлтгэн байршуулсан. "Сургууль" хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд Зөрчлийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Жендерт суурилсан хүчирхийлэл, замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зэрэг сэдвээр насанд хүрэгчдэд 2 удаа сургалт зохион байгуулж 59 иргэн, бага, дунд, ахлах ангийн сурагчдын дунд 3 удаа сургалт зохион байгуулж 199 сурагч хамрагдаж мэдлэгээ дээшлүүлсэн. Мөн "Миний баатар" гар зураг, захидлын уралдаанд 58 зураг, 23 захидал ирүүлснийг ангилал тус бүрээр шалгаруулж урамшуулан 135,0 төг, нөлөөллийн ажлын хүрээнд волейболын тэмцээнийг 2 насны ангилалаар зохион байгуулж 800,0 төг тус тус зарцуулсан. Арга хэмжээ-4. Сургалтад хамрагдсан хүний тоо-368, зарцуулсан хөрөнгө 935,0 төг. | 2024.01.02 2024.12.30 | 100 |
| 4 | Арга хэмжээ 2.4. Авлига, гэмт хэрэг, үе тэнгийн дарамт, осол, | Хүүхдийн осол гэмтэл, | Зохион байгуулсан | Сургалтад хамрагдах | Хүүхдийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх зөвлөмж бэлтгэн 200ш | 2024.01.02 2024.12.30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зөрчил, насанд хүрээгүй хүүхдийг бэлгийн хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах | хүчирхийлэл, дарамтаас урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа 10-аас доошгүй удаа зохион байгуулна.<br>Осол гэмтэлд өртсөн иргэний судалгааны сан бүрдүүлнэ. | сургалт -10 Хамрагдсан хүний тоо- 287 | хүний тоо- 360, цахим мэдээлэлийн тоо-4 | гарын авлага тараан олгосон. "Дээрэлхэл дэлгэрэх ёсгүй" аянд сумын ЕБС-ийн 1-12 дугаар ангийн сурагчид нэгдэж, анги удирдсан багшаар дамжуулан "Дээрэлхэл түүний хор уршиг", "Дээрэлхэлийн эсрэг бидний авах арга хэмжээ" зэрэг сэдвээр 1 цагийн мэдээлэл хийж 448 сурагч хамрагдсан. ЕБС-ийн 6, 7, 8-р ангийн 3 бүлгийн сурагчидтай "Өглөөний цай-Өглөөний уулзалт"-ыг хийж 65 хүүхэд хамрагдаж "Үе тэнгийн дээрэлхэлт"-ийн талаар санал бодлоо солилцож, сургуулийн орчинд үйлдэгдэх дээрэлхэлтийг таслан зогсооход сурагчид болон багш, ажилчид, эцэг эхчүүд юу хийх талаар саналаа хуваалцаж, бие биенээ урмын үгээр шагнасан. "Найз байя" аяны хүрээнд үе тэнгийн дээрэлхэлт, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулсан рийл бичлэгийн уралдаанд 6 бичлэг ирүүлснийг 3 байр эзлүүлж шагнаж урамшуулсан. Авлига гэмт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр дунд, ахлах ангийн сурагчдын дунд сургалт зохион байгуулж 2 ангийн 56 сурагч хамрагдаж мэдлэг боловсролоо дээшлүүлж, сурагчдын дунд зохион байгуулсан "Авлигыг тэвье-Сэргийлье" рийл бичлэгийн уралдаанд 6 бичлэг ирүүлснийг 3 байр эзлүүлж Дурсамж 150.0 төгрөгөөр шагнаж урамшуулсан. Сургалт, арга хэмжээ-5, хамрагдсан хүний тоо-569, зарцуулсан хөрөнгө-420,0 төг | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | Арга хэмжээ 2.5. Хүүхдийг хөдөлмөрийн мөлжлөгөөс сэргийлэх, гэр бүлийн хүчирхийлэл, сэтгэл зүйн дарамт зэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах | Хүүхдийн тэвчишгүй хөдөлмөрийн талаар иргэдэд 2-оос доошгүй удаа сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулсан байна. | Зохион байгуулсан сургалт-2 Хамрагдсан хүний тоо-48 | Уралдаанч хүүхдийн аюулгүй байдлын талаар 1 удаа сургалт зохион байгуулна. | Нарийнтээл сумын 4-р багийн нутаг дэвсгэр болох Нарийн хэмээх газар 2024 оны 02 дугаар сарын 11-ны өглөө буюу шинийн 2-нд хурдан морины уралдаан нууцаар зохион байгуулагдаж 1 хүүхэд мориноос унасан зөрчил илэрсэн тул холбогдох байгууллагад мэдэгдэж, улмаар хүүхдийн улсын байцаагч ирж ажиллан уралдаан зохион байгуулсан 2 уяачийг зөрчлийн тухай хуулиар торгож, 1 уяачид хэрэг үүсгэн прокорт шилжүүлсэн бөгөөд дахин ийм зөрчил бүртгэгдээгүй. Өвөл, хаврын улиралд хурдан морины уралдаан, үсэргээ, сунгаа зохион байгуулахгүй байх Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд постер бэлтгэн сумын цахим групп тавьсан. Хандалтын тоо:375<br>Уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг хангах, стандартын хувцас хэрэглэлээр хангах, даатгалд хамруулах талаар гарын авлага бэлтгэн 200ш хэвлэн тараасан.<br>Сумын баяр наадам, Баянтээг багийн ЕБС-ийн 60 жилийн ойн баяр наадамд уралдаанч хүүхдийн бүртгэл хийж давхардсан тоогоор 241 хүүхэд бүртгэн аюулгүй байдлыг хангаж ажилласан бөгөөд уралдааны үеэр 3 хүүхэд мориноос унаж 1 хүүхэд хөнгөн бэртэл авсныг эмнэлэгийн анхны тусламж үзүүлж ажилласан.<br>Арга хэмжээ-3, зарцуулсан хөрөнгө-79,8 төг | 2024.01.02 2024.12.30 | 90 |
| **Зорилт 3. Хүүхдийн эрх, хөгжил, хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж, салбар дундын хамтын ажиллагааг сайжруулан хүүхдэд ээлтэй аюулгүй орчин бүрдүүлнэ**" зорилтын хүрээнд | | | | | | | |
| | Арга хэмжээ 3.1. Хүүхдийн эрсдлийн мэдээллийн сан бий | -Нөхцөл байдлын | цахим-1, танхим-2 | 10-аас доошгүй өрхөд нөхцөл | Хамтарсан багийн 4 гишүүн чадавхжуулах сургалтад | 2024.01.01 2024.12.30 | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | болгож, хүүхэд хамгааллын хамтарсан багийг чадавхжуулах, үйл ажиллагааг санхүүжүүлэх, www.nams.mn программд үйлчилгээг бүртгэх | үнэлгээний тоо-10<br>-Судалгааны сангийн тоо-12<br>-Nams.mn программын ашиглалтыг сайжруулсан байна. | сургалтанд хамрагдсан. Судалгааны сан-10 | байдлын үнэлгээ хийж, төлөвлөгөө боловсруулсан байна. | хамрагдсан. Сургууль болон дотуур байрны хяналтын камерын хяналт" хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд дотуур байрны камерыг шалгаж, камер шүүлтийн дэвтэр, сурагчдын ирц, гараас гарт хүлээлцсэн дэвтэр зэргийг шалгаж, зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. Эрсдэлд мэдээллийн санд 21 өрхийн 38 хүүхэд, хагас өнчин-29 бүтэн өнчин-2, ХБхүүхэд 16, эхтэйгээ амьдардаг 27 өрхийн 41 хүүхэд, аавтайгаа амьдардаг 4 өрхийн 4 хүүхэд, үрчлэгдсэн 20, сургууль завсардсан 1, унаач 28 хүүхдийн судалгааг шинэчилсэн. Гэр бүлийн хүчирхийллийн дуудлага 5 бүртгэгдэж, нийт 5 дуудлага мэдээлэл дээр ажилласан.<br>Зарцуулсан хөрөнгө -217, 5 төг | | |
| 2 | Арга хэмжээ 3.2. Хүүхдийн тусламжийн 108 утасны дуудлага мэдээлэл, шийдвэрлэлт | -Ирсэн дуудлагын бүртгэл хөтлөнө.<br>Шийдвэрлэлт 100%-д хүргэнэ. | Бүртгэгдсэн дуудлага-5, шийдвэрлэлт - 100% | Ирсэн дуудлага мэдээллийн тоогоор | Хүүхдийн тусламжийн 108 дугаарын утсанд хүчирхийллийн дуудлага 1 бүртгэгдсэн. Тус дуудлагын мөрөөр Хамтарсан багаар ажиллаж шийдвэрлэсэн. | 2024.05.01<br>2024.12.30 | 100 |
| 3 | Арга хэмжээ 3.3. Хүүхдийн эрх, хөгжил хамгааллын үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлж, салбар дундын хамтын ажиллагааг сайжруулан, хүүхдэд ээлтэй аюулгүй орчин бүрдүүлэх | -Зохион байгуулсан арга хэмжээний бүртгэл хөтлөнө.<br>-Хүүхдийн өөрөө удирдах байгууллагын дэлгэрэнгүй судалгааны сантай болно. | - | Хүүхдийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг эрчимжүүлэх 2-оос доошгүй сургалт зохион байгуулна. | Хужирт суманд зохион байгуулагдсан "Mini Youth Power In Uvurkhangai" байгальд ээлтэй сурагчдын чуулганд 2 сурагчыг оролцуулсан.Тэдний санаачлагаар "Mini youth power in Nariinteel" байгальд ээлтэй залуусын чуулганыг ЕБС-тай хамтран зохион байгуулж 8-11 дугаар ангийн 58 сурагч, Арвайхээр сумаас 7 сурагч урилгаар оролцон 6 сэдвийн хүрээнд байгаль орчны болон хүүхэд хөгжлийн асуудлуудыг микро болон макро түвшинд шийдэл гарган бусдадаа танилцуулж, | 2024.01.01<br>2024.12.30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сайжруулж, санал бодлоо солилцон сум орон нутаг, сургуульд тулгамдаж буй асуудлуудыг хэлэлцэж, оновчтой шийдлийн хамтдаа гарган ажилласан. Тус арга хэмжээнд 1050.0 төгрөг зарцуулсан. "Өсвөрийн сэргийлэгч" бүлгэмийн сурагчдийг чадавхжуулах сургалтыг сумын цагдаа, хэсгийн төлөөлөгч нар хамтран хийж 13 хүүхэд хамрагдсан. Монгол банкны аймаг дахь салбар, Насан туршийн нэгжтэй хамтран "Санхүүгийн боловсрол" олгох сургалтыг 2 удаа зохион байгуулж 85 хүүхэд хамрагдсан. Мөн what3words буюу 3 үгт хаягийг таниулах сургалтыг дунд, ахлах ангийн сурагчдын дунд зохион байгуулж 132 хүүхэд мэдээлэл авч, 68 утсандаа тус хаягийг суулгасан. Аймгийн Насан туршийн боловсролын нэгжтэй хамтран зохион байгуулсан "Охид, хөвгүүдийн эрүүл мэндийн боловсрол олгох" сургалтад 72, "Бяцхан санхүүч" сургалтад 24 сурагч тус тус хамрагдсан.<br>Арга хэмжээ -4, хамтран ажилласан байгууллага-4, хамрагдсан хүний тоо -239 | | |
| 4 | Арга хэмжээ 3.4. Төр, хувийн хэвшилийн байгууллагуудад "Хүүхэд хамгааллын бодлого"-ыг хэрэгжүүлэх, арга зүйгээр хангах | -Төрийн 5 байгууллагад арга зүйн зөвлөгөө өгч ажилласан байна. | "Хүүхэд хамгааллын бодлого-"той байгууллагын тоо –3, | "Хүүхэд хамгааллын бодлого" хэрэгжүүлэх байгууллагын тоог 1-ээр нэмэгдүүлнэ. | ЕБС, СӨББ, Эрүүл мэндийн төв зэрэг байгууллагууд "Хүүхэд хамгааллын бодлого"-ыг хэрэгжүүлж ажиллаж байна.<br>Ерөнхий боловсролын сургууль сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран сургууль эцэг эхийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтийг сайжруулах, | 2024.01.01<br>2024.12.30 | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сурталчлан таниулах зорилгоор "Анзаарч хамгаалъя" эцэг эх, асран хамгаалагчдын сургалт, уулзалтыг 2 удаа зохион байгуулан ажилласан. Сургалтанд давхардсан тоогоор 20 бүлгийн болон дотуур байрын сурагчдын 107 эцэг эх, асран хамгаалагчид оролцсон. Сургалтаар "Хүүхэд гэмт хэрэгт холбогдох шалтгаан нөхцөл", сургуулийн "Хүүхэд хамгааллын багийн үйл ажиллагааны танилцуулга, хэрэгжиж байгаа ажил, эцэг эхчүүдийн анхаарах асуудлууд", "Осол гэмтэл, түүний шалтгаан, үр дагавар" мэдээлэл хүргэж, сургалтын төгсгөлд эцэг эх, асран хамгаалагчдыг 5 бүлэгт хуваан хэлэлцүүлэг явуулсан. Мөн 40 минутын хичээлд оролцуулж хичээл сургалтын үйл ажиллагаатай танилцуулсан. Хичээлээс гадуурх хөтөлбөрөөр хэрэгжиж байгаа "Бүх нийтээрээ бөгж нийлүүлье" уламжлалт тоглоом наадгайг сурталчилж, үүний дараа өглөөний цай уух болон дотуур байрын сурагчдын хоолыг амталсан бөгөөд сургалтын төгсгөлд эцэг эхчүүдийн дунд АХА танин мэдэхүйн тэмцээнийг зохион байгуулсан. Мөн оролцогчдод Боловсролын ерөнхий хуулийн эцэг эх, асран хамгаалагч, суралцагчийн эрх үүрэг сэдвээр гарын авлага боловсруулан тарааж түгээн дэлгэрүүлсэн. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | Арга хэмжээ 3.5. "Эцэг, эхийн зөвлөл"-ийн үйл ажиллагааг тогтмолжуулах, арга зүгээр хангах | Төрийн байгууллагын 80% нь эцэг эхийн зөвлөлтэй болсон байна. Эцэг эхийн зөвлөлийн 50% үйл ажиллагаа нь тогтмолжсон байна. | Эцэг эхийн зөвлөл -4 | Эцэг эхийн зөвлөлийн тоог 1-ээр нэмэгдүүлнэ. | ЕБС-ийн эцэг эхийн зөвлөл ОУ-ын гэр бүлийн өдрийг тохиолдуулан багш, ажилчид болон тэдгээрийн гэр бүлийн гишүүдийг урьж "Хамтдаа байхдаа жаргалтай" гар бөмбөгийн тэмцээнийг, СӨББ-ын гэр бүлийн зөвлөлөөс бага насны хүүхэдтэй эцэг эхчүүдийн дунд "Үдшийн цэнгүүн" арга хэмжээг зохион байгуулж, "Гэр бүлийн аз жаргал гэж юу вэ" сэдэвт сургалт хийсэн бөгөөд хосын хөгжөөнт тоглоом, азын сугалаа зэрэг арга хэмжээг зохион байгуулж ажилласан нь 80 иргэн хамрагдсан байна. ОУ-ын гэр бүлийн өдрийг тохиолдуулан ЕБС-ийн гэр бүлийн зөвлөлөөс байгууллагын багш, ажилчид болон тэдгээрийн гэр бүлийн гишүүдийг урьж "Хамтдаа байхдаа жаргалтай" гар бөмбөгийн тэмцээнийг зохион байгуулан ажиллаж нэг өдрийг хөгжилтэй өнгөрүүлж, спортоор өрсөлдлөө. Тэмцээнд 15 гэр бүлийн 30 хос 6 багт хуваагдаж оролцсон бөгөөд хүрэлцэн ирсэн гэр бүлийн гишүүдийн дунд азын сугалаа явуулж, супер азтанаа тодруулж ажилласан байна. | 2024.01.01<br>2024.12.30 | 70 |

**Нэмэлт үүрэг даалгавар /арга хэмжээ/-ийн биелэлт**.

| № | Үүрэг даалгавар /арга хэмжээ/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин /биелэлт/ | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Арга хэмжээ: 1<br>"Залуучуудын фитнессийн тоног төхөөрөмж худалдан авах тендер"- | | | Тендер амжилттай зохион байгуулагдсан байна. | Тендерт оролцохоор 2 ААНБ-аас үнийн санал ирүүлснийг үнэлгээний хорооны хурлаар | 2024.04.01<br>2024.05.15 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ийн Үнэлгээний хорооны даргаар ажилласан.<br><br>Сумын Засаг даргын захирамж<br>2024.03.05 А/37 | | | | хэлэлцэж Санаа мед Трейд ХХК 48970,000 төгрөгийн үнийн санал шалгарсан бөгөөд тоног төхөөрөмжөө бүрэн хүлээлгэн өгч ашиглалтад оруулсан. | | |
| 2. | Арга хэмжээ: 2<br>"Эрүүл мэндийн төвийн шатахууны нийлүүлэх" тендерийн нарийн бичгийн даргаар ажилласан.<br>ЭМТ-ийн даргын тушаал<br>2024.04.16 А/02 | - | - | Тендер амжилттай зохион байгуулагдсан байна. | Тендер амжилттай зохион байгуулж НИК-ШТС 33805,276 төгрөгийн үнийн санал ирүүлж шалгарсан. ЭМТ-д зөвлөмж хүргүүлж гэрээгээ байгуулсан. | 2024.05.14<br>2024.06.15 | 100 |
| 3. | Арга хэмжээ:3<br>"Малын гоц халдварт өвчний зардал" тендерийн үнэлгээний хорооны нарийн бичгийн даргаар ажиллаж байна.<br>Сумыг Засаг даргын захирамж<br>2024.02.17 А/31 | | | Тендер амжилттай зохион байгуулагдсан байна. | Уг тендер нь 4 удаа цахим системээр зарлагдснаас 3 нь амжилтгүй /оролцогчгүй/ болж , 4-дэх удаагийн урилгад Бумбат –Ур нөхөрлөл 22950.000 төгрөгийн үнийн санал ирүүлж шалгарсан. | 2024.04.01<br>2024.06.15 | 100 |
| 4. | Арга хэмжээ:4<br>"СӨББ-ын хоол нийлүүлэх" тендер Үнэлгээний хорооны гишүүнээр ажилласан.<br>СӨББ-ын эрхлэгчийн тушаалаар | | | Тендер амжилттай зохион байгуулагдсан байна. | Уг тендерийг 2 багцтай зарласан бөгөөд багц 1-д Цэвээнбал ХХК шалгарч гэрээ байгуулан, хуваарийн дагуу бараагаа нийлүүлэн ажилласан. | 2024.05.01<br>2024.10.01 | 100 |
| 5 | Арга хэмжээ: 5<br>"Зорилтот жилийн ажлын хэсэг"<br>Сумын Засаг даргын захирамж<br>2024.02.22 А/31 | | | Төлөвлөгөөнд тусгагдсан өөрт хамааралтай ажлыг хийж гүйцэтгэсэн байна. | Ажлын хэсэгт гишүүнээр ажиллаж төлөвлөгөөний дагуу үүрэгт ажлаа бүрэн биелүүлсэн. Сумын ИТХ-аар төлөвлөгөөний биелэлт 85,5 хувьтай үнэлэгдсэн. | 2024.03.01<br>2024.11.30 | 100 |
| 6 | Гамшгаас хамгаалах команд штабын сургуулилт | | | | Мэргэжлийн зориулалттай ангийн Анхны тусламжийн бүлгийн ахлагчаар томилогдож бүлгийн 14 гишүүнийг гамшгаас хамгаалах команд штабын сургуулилтанд бүрэн оролцуулсан. Бүлгийн гишүүддээ анхны тусламж хэрхэн үзүүлэх талаар сургалт, зөвлөгөө авч дадлага ажил хийлгэж 13 албан хаагч оролцсон. | 2024.05.09.<br>2024.05.10 | 100 |
| 7 | Арга хэмжээ: 6<br>"Ёс зүйн дэд хороо байгуулах тухай"<br>Сумын ЗДТГ-ын даргын тушаал | | | Төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг ханган ажилласан байна. | Ёс зүйн дэд хорооны ажлын төлөвлөгөөг 2 зорилтын хүрээнд 7 ажил хийхээр төлөвлөсөн. Ёс зүйн зөрчил гаргасан албан | 2024.02.01<br>2024.12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 2023.06.01 А/08<br>Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн даргаар ажиллаж байна. | | | | хаагчтай холбоотой өргөдөл, гомдол бүртгэгдээгүй болно. | | |
| 8 | Арга хэмжээ: 7<br>“Сумын сонгуулийн хороо байгуулах тухай”<br>Аймгийн Сонгуулийн хорооны тогтоол<br>2024.04.24 №01<br>Сумын Сонгуулийн хорооны гишүүнээр ажиллаж байна. | | | МУ-ын их хурлын сонгуулийг амжилттай зохион байгуулсан байна. | Сумын сонгуулийн хороо нь төлөвлөгөө, ажил үүргийн хуваарь гаргаж, хэсгийн хороодыг байгуулан, сургалт зохион байгуулж, холбогдох хууль тогтоомж, журам, гарын авлагыг тараан олгосон. УИХ-ын сонгуулийг үр дүнтэй зохион байгуулж ажилласан. | 2024.05.01<br>2024.06.30 | 100 |
| 9 | Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ –ын сонгуулийг зохион байгуулах сумын Сонгуулийн хорооны гишүүн | | | Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ –ын сонгуулийг амжилттай зохион байгуулсан байна. | Сумын сонгуулийн хороо нь төлөвлөгөө, ажил үүргийн хуваарь гаргаж, хэсгийн хороодыг байгуулан, сургалт зохион байгуулж, холбогдох хууль тогтоомж, журам, гарын авлагыг тараан олгосон. Орон нутгийн сонгуулийг амжилттай зохион байгуулж ажилласан. | 2024.09.01<br>2024.10.12 | 100 |
| 10 | Гэрэлтүүлгийн засварын тендер | | | Тендер амжилттай зохион байгуулагдсан байна. | Ажлын хэсэг хуралдаж техникийн тодорхойлолтоо боловсруулж 3 ААНБ-д 2 удаа санал хүргүүлсэн боловч үнийн санал ирүүлээгүй. | 2024.09.20<br>2024.12.10 | 40 |

**Хоёр: Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт.**

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин /биелэлт/ | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| Зорилт 1. “Салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомж”-ийг судлах , тасралтгүй хөгжүүлэх “зорилтын хүрээнд | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1.Төрийн албаны тухай хуулийн 29.1-д заасан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдах | Суралцсан кредит цаг | - | Сургалтын талаар судалсан байна. | Төрийн албаны тухай хуулийн 29.1-д шаардлагад нийцээгүй тул Нийгэм, сэтгэл судлалын дээд сургуульд Нийгмийн ажилтан мэргэжлээр онлайн эчнээ ангид суралцаж байна. | 2024.04.01<br>2024.12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Төрийн албаны зөвлөлийн 7:4:10 сургалтанд 19 удаа хамрагдсан. | | |
| 2. | Арга хэмжээ 1.2.Мэдээллийн технологийн хэрэглээний болон салбарын хууль тогтоомжид заасан зайлшгүй шаардлагатай ур чадварыг бие даан эзэмших | -Шинээр гарсан болон нэмэлт өөрчлөлт орсон хууль тогтоомжийг судлах<br>-Комьпютерийн төрөл бүрийн программыг ашиглаж сурах | - | 2-оос доошгүй хууль судалсан байна.<br>Постер, контент хийх арга барилд суралцсан байна. | Хүүхэд хамгаалалын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, МУ-ын Их хурлын сонгуулийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ –ын сонгуулийн тухай хууль бусад дүрэм журмыг бие даан судлан ажиллаж байна. Мөн 15 төрлийн постер бэлтгэн цахим сүлжээнд байршуулсан. Хүртээмжийн too: 1057 | 2024.01.02<br>2024.12.10 | 100 |
| | | | | | | | |

ТАЙЛАН ГАРГАСАН:

НИЙГМИЙН БОДЛОГЫН МЭРГЭЖИЛТЭН /Ц.САЙНБИЛЭГ/ 2024.12.05

/албан тушаал/ /нэр, гарын үсэг/ /огноо/

НАРИЙНТЭЭЛ СУМЫН НИЙГМИЙН БОДЛОГЫН МЭРГЭЖИЛТЭН Ц.САЙНБИЛЭГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ** /АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ/

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин/биелэлт | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| ГУРАВ.БАТЛАН ХАМГААЛАХ, ОНЦГОЙ БАЙДЛЫН САЛБАР | | | | | | | |
| НЭГ. "Зорилт 3.1.Хүүхэд, залуучуудад цэрэг-эх оронч үзэл, хүмүүжил төлөвшүүлэх ажлыг хариуцан зохион байгуулна." ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 3.1.1 | Цэргийн насны болон өсвөр насны залуучуудын дунд эх оронч үзэл, хүмүүжил олгоход чиглэсэн 2-оос доошгүй сургалт, сурталчилгааны арга хэмжээг зохион байгуулах | Арга хэмжээний тоо, оролцох бүрэлдэхүүн | 2023 онд сум бүр 2-оос доошгүй арга хэмжээнд хамрагдан оролцсон. | Сургалт, сурталчилгаанд хамрагдсан иргэдийн тоо нэмэгдсэн байна. | ЭМТ, Насан туршийн боловсролын нэгж хамтран цэргийн насны залуучуудын дунд "Мансуурулах бодис болон архи, тамхины хор уршиг", "Цэргийн албаны тухай хууль", "Нутгаараа бахархая" зэрэг сэдвээр 2 удаа сургалт зохион байгуулж 78 залуучууд хамрагдсан. Хужирт суманд зохион байгуулагдсан "Mini Youth Power In Uvurkhangai" байгальд ээлтэй сурагчдын чуулганд 2 сурагчыг оролцуулсан.Тэдний санаачлагаар "Mini youth power in Nariinteel" байгальд ээлтэй залуусын чуулганыг ЕБС-тай хамтран зохион байгуулж 8-11 дугаар ангийн 58 сурагч, Арвайхээр сумаас 7 сурагч урилгаар оролцон 6 сэдвийн хүрээнд санал бодлоо солилцон сум орон | 2024.02.08 2024.12.30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | нутаг, сургуульд тулгамдаж буй асуудлуудыг хэлэлцсэн. Тус арга хэмжээнд 1050.0төгрөг зарцуулсан. Аймгийн "Иргэний засаглал" төрийн бус байгууллагын тэргүүн Б.Уганхүү урьж ЕБС-ийн дунд, ахлах ангийн сурагчдад чиглэсэн "Хэрхэн мэргэжлээ сонгох вэ?" "Өөртөө манлайл" зэрэг сэдвээр 120 минутын лекцэнд 215 хүүхдийг хамруулж ажилласан. | | |
| 3.1.2 | Аймгийн Засаг даргын нэрэмжит аймгийн аварга шалгаруулах цэрэг-спортын "Дөл-2024" цогцолбор тэмцээнд ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдыг бэлтгэн оролцуулах | Баг, тамирчдын оролцоогоор | 2022 онд 13 сумын 18 баг оролцсон, 2023 онд төсөв санхүүгээс шалтгаалан явагдаагүй. | Сум тус бүр 1-2 баг тамирчдыг оролцуулна. | Бэлтгэл хангагдаагүй, санхүүгийн асуудлаас болж оролцож чадаагүй. | 2024.04.01 2024.06.30 | 0 |
| | Зорилт 3.4.Орон нутгийн гамшгаас хамгаалах чадавхыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулж ажиллана. | | | | | | |
| 3.4.5 | "Өсвөрийн аврагч-2024" аймгийн аварга шалгаруулах тэмцээнд сурагчдыг оролцуулах | Тэмцээнд оролцсон сурагчдын тоогоор | 2023 онд Өсвөрийн аврагч нарыг чадавхжуулах сургалтыг 8 сургуулийн 120 сурагчдад зохион байгуулсан. | "Өсвөрийн аврагч-2024" аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулна. | Бэлтгэл хангагдаагүй, санхүүгийн асуудлаас болж оролцож чадаагүй. | 2024.04.01 2024.10.30 | 0 |
| ХОЁР: Зорилт 5.5. "Хүн амын эрүүл мэндийг сайжруулах зорилгоор идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэн, гэр бүлийг дэмжиж, нийтийн биеийн тамирыг хөгжүүлнэ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5.5.1 | Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй "Эрүүл Монгол хүн" үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлэх ажлын хүрээнд "Эрүүл чийрэг Өвөрхангайчууд" уриатай бүх нийтийг хамарсан аян өрнүүлэх | -Зохион байгуулсан арга хэмжээний тоо<br>-Хамрагдсан иргэдийн тоо | - | - | СӨББ-ын 18 албан хаагч өглөөний дасгалыг хийж хэвшсэн.<br>Соёлын төвтэй хамтран Эрүүл чийрэг Нарийнтээлчүүд уриан дор "Биелгээ үндэсний хөдөлгөөн", дасгал хийцгээе зэрэг хөдөлгөөн өрнүүлсэн 13 иргэн 14 хоног хичээллэж иргэдийн тоо буурсаар үр дүн гараагүй. | 2024.02.08<br>2024.06.30 | 40 |
| 5.5.2 | Иргэдийн дунд "Миний нутаг сайхан" спортын наадмын анхан шатны арга хэмжээг зохион байгуулах | Хамрагдсан иргэдийн тоо | - | - | Дээд шатны байгууллагаас удирдамж ирээгүй, аймгийн хэмжээнд зохион байгуулагдаагүй | 2024.09.01<br>2024.10.30 | 0 |
| 5.5.3 | Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 53 дугаар зарлигийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Иргэдийн бие бялдрын түвшин тогтоох сорил"-ыг жилд 2 удаа авч, үр дүнг тооцож ажиллах | Сорилд хамрагдсан иргэдийн тоо | - | - | Бие бялдарын түвшин тогтоох сорилд эхний хагас жилийн байдлаар 6-17 насны 152 хүүхэд 26 иргэнийг хамруулсан. | 2024.04.01<br>2024.06.30 | 100 |
| 5.5.4 | Аймгийн Засаг даргын захирамжийн хэрэгжилтийг хангаж, сумын хэмжээнд төрийн болон аж ахуйн нэгж байгууллагад "Биеийн тамир, спортын хамтлаг" байгуулах ажлыг эрчимжүүлж, үйл ажиллагаа нь тогтмолжуулах | Хамтлагийн тоо | | Аймгийн хэмжээнд 58 | ЗДТГазар биеийн тамир спортын хамтлаг шинээр байгуулсан. | 2024.03.01<br>2024.06.30 | 70 |
| Зорилт 9.5. Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны "Хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах" 01 албан даалгавар, "Хүүхдийн эрхийн тухай" хуулийн хэрэгжилт, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжил, хамгааллын үйл ажиллагааны чанар хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд | | | | | | | |
| 9.5.1 | Сумын Хүүхдийн төлөө зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлж, хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжсэн үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах | Үйл ажиллагаанд хамрагдсан хүүхдийн эзлэх хувь | 43 хувь | 20 хувь | "Mini Youth Power In Uvurkhangai" байгальд ээлтэй сурагчдын чуулганд 2 сурагчыг оролцуулсан.Тэдний санаачлагаар "Mini youth power in Nariinteel" байгальд ээлтэй залуусын чуулганы ЕБС-тай хамтран зохион | 2024.01.02<br>2024.12.30 | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгуулж 8-11 дугаар ангийн 58 сурагч, Арвайхээр сумаас 7 сурагч урилгаар оролцон 6 сэдвийн хүрээнд байгаль орчны болон хүүхэд хөгжлийн асуудлуудыг микро болон макро түвшинд шийдэл гарган түүнийгээ бусдадаа танилцуулж, сайжруулж, санал бодлоо солилцон сум орон нутаг, сургуульд тулгамдаж буй асуудлуудыг хэлэлцэж, оновчтой шийдлийн хамтдаа гарган ажилласан. Тус арга хэмжээнд 1050.0 төгрөг зарцуулсан. "Өсвөрийн сэргийлэгч" бүлгэмийн сурагчдийг чадавхжуулах сургалтыг сумын цагдаа, хэсгийн төлөөлөгч нар хамтран хийж 13 хүүхэд хамрагдсан. | | |
| 9.5.2 | Сумын хамтарсан багийн үйл ажиллагааг эрчимжүүлж, эрсдэлт нөхцөлд байгаа гэр бүл, хүүхдүүдийн илрүүлж, хамгааллын болон хариу арга хэмжээг авч, үйлчилгээг шуурхай үзүүлэх | Хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулсан байдал<br>Кейс илрүүлсэн, шийдвэрлэсэн тоо<br>Үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо | 1<br>165<br>9710 | 1<br>165 | Хамтарсан багийн 4 гишүүн чадавхжуулах сургалтад хамрагдсан. Сургууль болон дотуур байрны хяналтын камерын хяналт" хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд дотуур байрны камерыг шалгаж, камер шүүлтийн дэвтэр, сурагчдын ирц, гараас гарт хүлээлцсэн дэвтэр зэргийг шалгаж, зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. Эрсдэлд мэдээллийн санд 21 өрхийн 38 хүүхэд, хагас өнчин-29 бүтэн өнчин-2, ХБхүүхэд 16, эхтэйгээ амьдардаг 27 өрхийн 41 хүүхэд, аавтайгаа амьдардаг 4 өрхийн 4 хүүхэд, үрчлэгдсэн 20, сургууль завсардсан 1, унаач 28 хүүхдийн судалгааг шинэчилсэн. Гэр бүлийн хүчирхийллийн дуудлага 5 бүртгэгдэж, нийт 5 дуудлага мэдээлэл дээр ажилласан. "Сургууль" хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд Зөрчлийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Жендерт | 2024.01.02<br>2024.12.30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | суурилсан хүчирхийлэл, замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зэрэг сэдвээр насанд хүрэгчдэд 2 удаа сургалт зохион байгуулж 59 иргэн, бага, дунд, ахлах ангийн сурагчдын дунд 3 удаа сургалт зохион байгуулж 199 сурагч хамрагдаж мэдлэгээ дээшлүүлсэн. Мөн "Миний баатар" гар зураг, захидлын уралдаанд 58 зураг, 23 захидал ирүүлснийг ангилал тус бүрээр шалгаруулж урамшуулан 135,0 төг, нөлөөллийн ажлын хүрээнд волейболын тэмцээнийг 2 насны ангилалаар зохион байгуулж 800,0 төг тус тус зарцуулсан. Мөн аймгийн Насан туршийн боловсролын нэгжтэй хамтран зохион байгуулсан "Байгууллагын соёл, харилцаа хандлага", "Зорилгоо тогтвортой тууштай барих нь" сургалтад төрийн албан хаагч 47 "Аз жаргалтай амьдрахуй" сургалтад 29 ахмад оролцсон. | | |
| 9.5.3 | Хүүхдийг эрсдэлт нөхцөлд орохоос урьдчилан сэргийлж, зорилтот өрх, гэр бүл, эрсдэлт нөхцөлд амьдарч буй хүүхдийг судлан тогтоож, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх, аюулгүй байдлыг хангах, шаардлагатай тусламж үйлчилгээ үзүүлэх | Эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхдүүдээс хүүхэд хамгааллын үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн эзлэх хувь | 85 хувь | 55 хувь | Аймгийн ГХУСАЗСЗ –тэй хамтран сумын иргэд, албан байгууллагуудын ажилтан, албан хаагчдад "Одоо л больё" аяны хүрээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулж 110 орчим иргэд, албан хаагчдыг хамруулсан.<br>Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Хүүхдийн эрхийн тухай хуулиар 200ш гарын авлага тараан олгосон.<br>Хүүхдийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх зөвлөмж бэлтгэн 200ш гарын авлага тараан олгосон. "Дээрэлхэл дэлгэрэх ёсгүй" аянд сумын ЕБС-ийн 1-12 дугаар ангийн сурагчид нэгдэж, анги удирдсан | 2024.01.02<br>2024.12.30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | багшаар дамжуулан "Дээрэлхэл түүний хор уршиг", "Дээрэлхэлийн эсрэг бидний авах арга хэмжээ" сэдвээр 1 цагийн мэдээлэл хийж 448 сурагч хамрагдсан. Мөн 6, 7, 8 дугаар ангийн 3 бүлгийн сурагчидтай "Өглөөний цай-Өглөөний уулзалт"-ыг хийж 65 хүүхэд хамрагдаж "Үе тэнгийн дээрэлхэлт"-ийн талаар санал бодлоо солилцож, сургуулийн орчинд үйлдэгдэх дээрэлхэлтийг таслан зогсооход сурагчид болон багш, ажилчид, эцэг эхчүүд юу хийх талаар саналаа хуваалцаж, бие биенээ урмын үгээр шагнасан. "Найз байя" аяны хүрээнд үе тэнгийн дээрэлхэлт, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулсан рийл бичлэгийн уралдаанд 6 бичлэг ирүүлснийг 3 байр эзлүүлж шагнаж урамшуулсан. Авлига гэмт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр дунд, ахлах ангийн сурагчдын дунд сургалт зохион байгуулж 2 ангийн 56 сурагч хамрагдаж мэдлэг боловсролоо дээшлүүлж, сурагчдын дунд зохион байгуулсан "Авлигыг тэвье-Сэргийлье" рийл бичлэгийн уралдаанд 6 бичлэг ирүүлснийг 3 байр эзлүүлж Дурсамж 150,0 төгрөг шагнаж урамшуулсан. Өвөл, хаврын улиралд хурдан морины уралдаан, үсэргээ, сунгаа зохион байгуулахгүй байх Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд постер бэлтгэн сумын цахим групп тавьсан. Хандалтын тоо:375. Хурдан морины уралдаан зохион байгуулахыг хориглосон цаг хугацаанд 1 уралдаан | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зохион байгуулсан зөрчил илэрч, дээд шатны байгууллагад мэдээлснээр холбогдох хүмүүст торгуулийн арга хэмжээ авч ажилласнаар дахин уралдаан зохион байгуулагдсан зөрчил илрээгүй. Уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг хангах, стандартын хувцас хэрэглэлээр хангах, даатгалд хамруулах талаар гарын авлага бэлтгэн 200ш хэвлэн тараасан. Сумын баяр наадам, Баянтээг багийн ЕБС-ийн 60 жилийн ойн баяр наадамд уралдаанч хүүхдийн бүртгэл хийж давхардсан тоогоор 241 хүүхэд бүртгэн аюулгүй байдлыг хангаж ажилласан бөгөөд уралдааны үеэр 3 хүүхэд мориноос унаж 1 хүүхэд хөнгөн бэртэл авсныг эмнэлэгийн анхны тусламж үзүүлж ажилласан. | | |
| 9.5.4 | Насанд хүрээгүй хүүхдийг бэлгийн хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон талт нөлөөлийн үйл ажиллагаа зохион байгуулах | Хүчирхийлэлд өртсөн хүүхдийн тоо буурсан байна | 12 | - | Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд бүртгэгдээгүй. | 2024.01.02 2024.12.30 | 100 |
| Зорилт 9.6. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлж, жендэрийн салбар дундын стратеги төлөвлөгөө (2022-2031)-ний хэрэгжилтийг хангаж бүх нийтийн жендэр ба эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, хүний эрхийг хамгаалах, хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааг оновчтой арга, хэлбэрээр зохион байгуулж ажиллана. | | | | | | | |
| 9.6.1 | Жендэрийн салбар дундын стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сургалт, нөлөөллийн арга хэмжээнд иргэд, олон нийтийг, зорилтот бүлгийг хамруулах, сум бүр | сургалт нөлөөллийн ажлын тоо<br>-Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар | 0 | | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө" бодлогын бичиг баримт нь 8 зорилтын хүрээнд 17 ажил хийхээр төлөвлөгдөж, 2 ажил хийгдээгүй байна. Зөрчлийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Жендер суурилсан хүчирхийлэл зэрэг сэдвээр насанд хүрэгчдэд 2 удаа сургалт зохион байгуулж 59 иргэн, жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аяны хүрээнд 37 уяачидад аяны талаарх мэдээлэл өгч | 2024.01.01 2024.12.30 | 70 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ажилласан. | |

ТАЙЛАН ГАРГАСАН:

| | | | |
|---|---|---|---|
| НИЙГМИЙН БОДЛОГЫН МЭРГЭЖИЛТЭН | ............................ | / Ц.САЙНБИЛЭГ / | 2024.12.05 |
| *( Албан тушаал )* | *( гарын үсэг )* | *( Нэр )* | *( Огноо )* |